



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ**

2023 оны 09 сарын 27 өдөр

Дугаар 473

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа сунгах,  
үнийг шинэчлэн тогтоох зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 2 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 7.1, 7.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн" төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 8 нэрийн, нийт 24,492,805.00 (хорин дөрвөн сая дөрвөн зуун ерэн хоёр мянга найман зуун таван) төгрөгийн балансын үнэ бүхий, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, цаашид ашиглаж болох хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, нийт үнийг 2,449,280.50 (хоёр сая дөрвөн зуун дөчин есөн мянга хоёр зуун наян төгрөг тавин мөнгө) төгрөгөөр хавсралтад заасны дагуу шинэчлэн тогтоохыг зөвшөөрсүгэй.

2. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Тавинбэх, "Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн" төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын захирал М.Түмэнжаргал нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хөрөнгийн ашиглалтын хугацаа, үнийг шинэчлэн тогтоох ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2023 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2023 оны 09 дүгээр сарын .....-ны өдрийн  
..... дугаар тогтоолын хавсралт

"Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн" төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, үлдэх өртөггүй ашиглалтын хугацааг сунгаж, үнийг шинэчлэн тогтоох хөрөнгийн жагсаалт

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Шинэчлэн тогтоосон үнэ, хугацаа		
							Нэг бүрийн үнэ (төгрөг)	Нийт үнэ (төгрөг)	Ашиглах хугацаа /жилээр/
1	Зөөврийн кондиешн /Тогнода/	2018.12.26	ш	1	299,900.00	299,900.00	29,990.00	29,990.00	2
2	Стенд	2018.12.28	ш	1	5,600,000.00	5,600,000.00	560,000.00	560,000.00	2
3	Усны Диспенсер WPU 9900F	2019.04.05	ш	2	620,000.00	1,240,000.00	62,000.00	124,000.00	2
4	Ус цэвэршүүлэх диспенсер APC	2019.10.16	ш	1	650,000.00	650,000.00	65,000.00	65,000.00	2
5	График GL240 Дата логгер	2019.12.25	ш	1	4,020,500.00	4,020,500.00	402,050.00	402,050.00	2
6	Амперклейшн /Ампер хавчаар-3/	2019.12.25	ш	1	3,701,500.00	3,701,500.00	370,150.00	370,150.00	2
7	Цахилгаан соронзон орон хэмжигч /BE-METP-50Гц комплект/	2019.12.25	ш	1	6,677,000.00	6,677,000.00	667,700.00	667,700.00	2

8	Зөврийн компьютер /Dell notebook 85m520/	2018.11.12	ш	1	2,303,905.00	2,303,905.00	2,303,905.00	230,390.50	230,390.50	2
	Нийт дүн			9	23,872,805.00	24,492,805.00	24,492,805.00	2,387,280.50	2,449,280.50	
				(ес)	(хорин гурван сая найман зуун далан хоёр мянга найман зуун тав)	(хорин дөрвөн сая дөрвөн зуун ерэн хоёр мянга найман зуун тав)	(хоёр сая гурван зуун наян долоон мянга хоёр зуун наян төгрөг тавин мөнгө)	(хоёр сая дөрвөн зуун дөчин есөн мянга хоёр зуун наян төгрөг тавин мөнгө)		